


# “ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 14 2022 оны 12-р сар

## ■ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд боловсруулсан уурхайн газар хэлбэршүүлэлтийн зураг төслийг “Эрдэнэс Силвер Ресурс ХХК”-д танилцуулан санал авах уулзалт 2022 оны 12-р сарын 6-ны өдөр боллоо. Компаниас томилсон ажлын хэсэг боловсруулсан зураг төсөлтэй танилцан баталгаажуулав. Цаашид зарим өөрчлөлт орох шаардлага үүсэж болзошгүй тохиолдолд тухай бүр холбогдох өөрчлөлтийг тусгах боломжтой талаар талууд тохиролцлоо. Ажлын хэсгийн зүгээс төлөвлөлтийн баг уурхайн байгууламж тус бүрийн инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж, хаалтын өртөг задал тооцоолох дараагийн шатны ажлаа эхлүүлэхэд татгалзах зүйлгүй гэдгээ илэрхийлэв.



Зураг 1. Газар хэлбэршүүлэлтийн зураг төслийг “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-иар хянуулан баталгаажуулах уулзалт

## ■ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА УУРХАЙН ХААЛТ



**COP27**  
SHARM EL-SHEIKH  
EGYPT 2022

Уур амьсгалын өөрчлөлт бидний өдөр тутмын амьдралд аль хэдийн нөлөөлөх болсон билээ. Дэлхийн дулаарлын улмаас хур тунадасны хэмжээ өөрчлөгдөж, далайн усны түвшин нэмэгдэж, шороон шуурга гэх мэт цаг агаарын гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдсээр байна. НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн 27-р бага хурал энэ оны 11-р сарын 6-20 өдрүүдэд Египетийн Шарм Эль-Шейх хотод болж өндөрлөсөн. Тус хурлын гол зорилго нь Парисын хэлэлцээр болон Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн зорилтуудын хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэхэд чиглэжээ.

Уур амьсгалын өөрчлөлт нь уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл бэрхшээл учруулдаг. Уурхайн нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөлтөд цаг агаарын аюул, эрсдэлүүдийг тооцоолж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ, стратегийг тодорхойлон тусгаж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Хаалтын төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үүсэж болзошгүй эрсдэл, боломжуудыг тодорхойлох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийдэг. Төлөвлөлтийн баг Салхитын уурхайн хаалттай холбоотой эрсдэлийн үнэлгээтэй танилцсан бөгөөд төслийн 3-р улиралд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуйц нөхөн сэргээлтийн стратегийг боловсруулна. Дараах арга хэмжээ, стратегийг хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

- Салхины элэгдэл, эвдрэлд өртөхөөс сэргийлэх, гадаргын усны нэвчилтийг дэмжих зорилгоор нөхөн сэргээж, хэлбэршүүлсэн газар дээр овон товон, жигд бус гадаргууг үүсгэх
- Хөрсний хучилт болон хучилтын материал нь хөрс болон усны элэгдэл, эвдрэлийг тэсвэрлэж чадахуйц хангалттай зузаан байхаар төлөвлөх
- Хөрс элэгдэж, эвдрэлд өртөх эрсдэлийг бууруулахын тулд ургамалжуулалтыг аль болох богино хугацаанд хийж гүйцэтгэх
- Хөрсний чийг хадгалах чадварыг дэмжих зорилгоор хөрсний органик бодисын агууламжийг нэмэгдүүлэх
- Ганд тэсвэртэй ургамал тарих
- Хэлбэршүүлсэн гадаргууг усны элэгдэл, эвдрэлээс хамгаалж усны хагалабар, суваг шуудуу байгуулж урсгах.

Уг стратегийг уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний болон олон улсын зөвлөхийн чиглүүлэг дор төлөвлөлтийн багийн бүх гишүүдийн оролцоотойгоор боловсруулах юм.

## ■ БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ БА УУРХАЙН ХААЛТ

Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг амжилттай гүйцэтгэх, хаалтын дараах экосистемийн тэнцвэрт байдлыг урт хугацаанд хангахад биологийн олон янз байдлын асуудал чухал нөлөөтэй. Биологийн олон янз байдлын тухай НҮБ-ын суурь конвенцын Талуудын 15-р бага хурал 2022 оны 12-р сарын 7-19 өдрүүдэд Канад улсын Монреал хотноо боллоо. Бага хурлаар талууд ирэх арван жилд биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой менежмент хэрэгжүүлэхэд чиглэсэн дэлхийн нэгдсэн стратеги чиглэлийг тодорхойлох “2020 оноос хойших Биологийн олон янз байдлын тухай даян дэлхийн зорилтууд”-ыг шинэчлэн батлахыг зорилоо (UNEP, 2022). 2030 он хүртэл дэлхийн амьдрах орчны 30 хувийг хамгаалахад чиглэсэн 4 зорилго, 23 зорилгыг тодорхойлж, түүнд шаардлагатай 200 тэрбум ам.долларын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг босгох, биологийн олон янз байдалд хор хөнөөлтэй төрөөс олгодог 500 тэрбум ам.долларын татаасыг зогсоох хэлэлцээрийг амжилттай байгуулла (CBC, 2022).



Зураг 2. Салхитын уурхайн талбайгаас шимт хөрсний дээж авч буй нь

усны эх үүсвэр зэрэг хүчин зүйлсийг тооцон янз бүрийн байршилд тарималжуулснаар ургамлын бүлгэмдэл бий болох нөхцөл бүрдэнэ. Ингэснээр нутгийн ан амьтад бэлчээр нутагтаа эргэн идээшлэх боломжтой. Тухайн нөхөн сэргээсэн газарт ургамал ургаж, ан амьтан өсөн үржиж олон янз байдал бий болж буйг нягтлахад хяналт-шинжилгээний ажил хийх зайлшгүй шаардлагатай.



Зураг 3. Салхитын уурхайн талбайд ургамлын бүрхэвчийн судалгаа хийж буй нь

уурхайн орчмын нутгийн унаган ургамлын төрөл зүйлийн судалгааг хийж гүйцэтгээд байна. Төслийн 3-р улиралд ургамал болон хөрсний үндсэний зөвлөхүүд олон улсын зөвлөхтэй хамтран уурхайн байгууламж тус бүрийн газар хэлбэршүүлэлтэд зориулсан биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулна. Экосистемийн тэнцвэрт байдлыг урт хугацаанд хангах зорилгоор олон төрлийн нутгийн унаган ургамлыг тарьж ургуулахаар төлөвлөгөөнд тусгах юм.

### Ашигласан материал

Canadian Broadcasting Corporation (CBC). 2022. Biodiversity agreement to protect planet reached at UN conference in Montreal. <https://www.cbc.ca/news/science/cop15-montreal-biodiversity-agreement-1.6690667>. Retrieved on December 19, 2022.

United Nations Environment Programme (UNEP). 2022. United Nations Biodiversity Conference. <https://www.cbd.int/conferences/2021-2022>. Retrieved on December 13, 2022.

International Council on Mining and Metals. 2019. Integrated mine closure: good practice guide.

International Organization of Migration (IOM). 2022. UN Climate change conference 2022 (COP27). <https://www.iom.int/cop27-addressing-human-mobility-driven-climate-change>. Retrieved on December 20, 2022.

### ХОЛБОО БАРИХ

Бид та бүхэнд Салхитын уурхайн хаалтын мэдээ мэдээллийг аль болох сонирхолтой байдлаар хүргэхийг зорьдог билээ. Төслийн оролцогч талуудын санал, сэтгэгдлийг сонсож, бэлтгэж буй мэдээ мэдээллийг уншигчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх нь чухал юм. Тиймээс та бүхэн төслийн сар тутмын мэдээтэй холбоотой санал сэтгэгдлээ бидэнтэй хуваалцана уу.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн захирал **Р.Алтангэрэл**тэй имэйл хаягаар холбогдоно уу. [r.altangerel@merit.mn](mailto:r.altangerel@merit.mn)